



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН

КОДЕКС



Энэхүү гарын авлагыг банкнаас бусад санхүүгийн байгууллагад зориулан боловсруулав.

ҮНЭГҮЙ ТАРААГДАНА

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧИМ

Компанийн засаглалын зорилго нь урт хугацааны туршид хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн бүрэн бүтэн байдлыг хөхиүлэн дэмжихэд шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчинг бүрдүүлэхэд туслах, ингэснээр эдийн засгийн өсөлт, нийгмийн оролцоог дэмжих явдал юм.

Анх 1999 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/ЭЗХАХБ/-аас компанийн засаглалын зарчмуудыг баталснаас хойш дэлхийн улс орнуудын бодлого боловсруулагч, хөрөнгө оруулагчид, компаниуд болон хувьцаа эзэмшигчдийн хувьд олон улсын жишиг баримт болсон байна.

Улмаар компаниуд төдийгүй эдийн засаг хурдацтай хөгжиж байсантай холбогдуулан өмнөх туршлагаудад тулгуурлан 2004 онд компанийн засаглалын зарчмуудыг шинэчлэн батламжилжээ.

Хамгийн сүүлд ЭЗХАХБ, Их Хорийн орнуудтай хамтарч 2015 онд компанийн засаглалын зарчмуудыг шинэчилсэн нь тэдгээрийг дэлхийн улс орнуудын хэмжээнд хэрэгжүүлэх боломжийг олгосон бөгөөд хууль эрх зүйн тогтолцоо нь өөр, хөгжлийн янз бүрийн шатанд явж буй олон орны туршлагыг тусгасан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д зааснаар Санхүүгийн зохицуулах хороонд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилтыг ханган ажиллах бүрэн эрхийг олгосон.

Санхүүгийн зохицуулах хороо 2007 онд компанийн засаглалын кодексыг 9 бүлэгтэйгээр боловсруулан анх баталсан бол 2014 онд тус кодексыг 10 бүлэгтэйгээр дахин шинэчилжээ.

Монгол Улсын “Компанийн засаглалын кодекс”-ыг эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шударга байдал, зах зээлд оролцогчдод үзүүлэх компанийн засаглалын эерэг нөлөө, ЭЗХАХБ болон олон улсын байгууллагуудын зөвлөмж, зөвлөгөө, дэлхийн бусад орнуудын сайн туршлага, мөн өөрийн орны онцлог, бодит нөхцөл байдал зэрэг асуудлыг харгалзан боловсруулсан.


Энэхүү кодексыг хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй хувьцаат компанид тухайлан зориулсан хэдий ч хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээд өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНДЭС



Зохицуулагч байгууллага нь компанийн засаглалын тогтолцоог нэвтрүүлэхдээ улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн нээлттэй, ил тод, шударга, үр ашигтай байдлыг хангах, зах зээлд оролцогчдыг дэмжих зэрэг асуудлыг харгалзан нийтийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэх боломжтой буюу хэт зохицуулалтаас зайлсхийсэн байдлаар бүрдүүлэх нь зохимжтой.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХИЙГ ТЭГШ ХАНГУУЛАХ



Хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал нь компанийн засаглалын тогтолцооны чухал үзүүлэлт бөгөөд хувьцаа эзэмшигчид дараах эрхүүдийг эдэлнэ.

- хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох
- ногдол ашиг авах
- санал өгөх
- сонгох ба сонгогдох
- мэдээлэл авах
- хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах
- нэмж шинээр гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах
- компанийн үйл ажиллагаанд шалгалт хийлгэхийг шаардах
- компанийг татан буугдахад үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх

МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД



- ✓ Мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь компанийн засаглалын бодлого, санал өгөх бодлого, томоохон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах зэрэг журмыг ил тод, нээлттэй болгоно.
- ✓ Компани нь мэргэжлийн хөрөнгө оруулагчид тэдний томоохон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг батлан ил тод нээлттэй болгосон байна.
- ✓ Мэргэжлийн хувьцаа эзэмшигчид ба хувьцаа эзэмшигчид энэхүү кодекст заасан үндсэн эрхээ урвуулан /хэтрүүлж ашиглах, буруугаар ашиглах, зарчимд заасан эрхээ зөрчих/ ашиглаж үгсэн хуйвалдахаас бусад тохиолдолд өөр хоорондоо харилцан зөвлөлдөх боломжийг бүрдүүлсэн байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ



- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага байх бөгөөд компанийн бизнесийн үйл ажиллагааг хянан санхүүгийн болон санхүүгийн бус бүхий л мэдээллээр хангагдаж, шийдвэр гаргах ба ногдол ашгийн бодлогыг тодорхойлно.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг хөтөлбөрт тодорхой тусгаж өгөхөөс гадна өөрийн биеэр оролцож чадахгүй хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг нь хангаж өгнө.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон шийдвэрийг нээлттэй, ил тод, шуурхай хүргүүлсэн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)



ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлон түүний хэрэгжилтэд хяналт тавьж удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллана. Үүний тулд аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, туршлага бүхий хувь хүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгон ажиллуулна. ТУЗ-ийн дэргэдэх хороод:

- цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо
- аудитын хороо
- эрсдэлийн удирдлагын хороо

Эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Гүйцэтгэх захирал эсвэл гүйцэтгэх удирдлагын баг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.



САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ



✓ Санхүүгийн тайлагналын үндсэн зорилго бол компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх байдаг.

✓ Компани нь найдвартай санхүүгийн тайлагналын системийг бий болгохын тулд олон улсын стандартад нийцсэн санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, мөн сонирхлын зөрчлөөс ангид бие даасан хөндлөнгийн аудиторыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно.

✓ Мөн компани нь олон улсын сайн туршлагын дагуу бизнесийн тодорхойлолт, санхүүгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн өөрчлөлт, бэлэн мөнгөний урсгал болон аливаа эрсдэлийн хүчин зүйлсийг нээлттэй болгосон мэдээллүүдийг жилийн үйл ажиллагааны тайландаа тусгасан байна.

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО



✓ Дотоод хяналт нь компанийн удирдлага үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэн түүний дагуу удирдамж заавраар газар, хэлтсүүдийг ханган ажилладаг бөгөөд дараах асуудалд чиглэсэн үйл ажиллагааг явуулна.

- санхүүгийн тайлагналын бодит байдал
- мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангах
- компанийн эрсдэлийг үнэлэх үйл ажиллагаа
- компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх
- хууль, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих
- ажлын байрны хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал түүний үйл ажиллагааны горимын хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт тавих
- дотоод хяналтын үйл ажиллагааны тайланг ТУЗ-д тайлагнах.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



ТУЗ нь санхүүгийн нөхцөл шаардлага, хууль тогтоомжийг дагаж мөрдөх болон гадаад ба дотоод эрсдэлийг удирдах тогтолцоогоор хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна. Удирдлагын баг нь эрсдэлийн удирдлагын дүрэм, журмыг боловсруулан хэрэгжилтэд нь хяналт тавина.

ОРОЛЦОГЧ ТАЛУУД



Компани нь оролцогч талуудын (ажилчид, зээлдүүлэгчид, харилцагчид, ханган нийлүүлэгчид, иргэд, олон нийт) эрхийг хүндэтгэн шийдвэр гаргахдаа тэдний ашиг сонирхол, байгаль орчин болон нийгмийн хариуцлагын асуудлуудыг харгалзан үзнэ.


Компани нь оролцогч талуудтай холбогдох шаардлагатай бүхий л мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.

“САЙН” ЗАСАГЛАЛЫН ҮР ДҮН

- ✓ Сайн засаглалыг нэвтрүүлэх зохистой тэнцвэрт хяналтын тогтолцоо нь компанийн хувьцаа эзэмшигчид, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон санхүүгийн зуучлагчид, үйлчилгээ үзүүлэгч нарыг өөрийн үүргээ тус тус гүйцэтгэхэд урамшил, зөв хөшүүрэг болдог.
- ✓ Компанийн засаглалын мөн чанар нь компанийн цаашдын өсөлтөд шаардагдах хөрөнгийг босгоход компаниас гарах өртөгт шууд нөлөөлж, хөрөнгийг шууд болон шууд бусаар олгож буй этгээдэд шударга, адил тэгш нөхцөлтэйгөөр компанийн үнэ цэнийг бий болгоход оролцож, үр шимийг нь хүртэх итгэлцлийг бүрдүүлнэ.




 www.frc.mn

 51-264444

 webmaster@frc.mn

 www.facebook.com/FRC.of.Mongolia

 Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160